

БАРБАДОС УЛСЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Нутаг дэвсгэр	439 км ²
Хүн ам	Хүн амын тоо: 281,998 мянга (2023 он) Бүтэц, үндэстэн ястны эзлэх хувь: африк 92.4%, холимог 3.1%, цагаан 2.7%, индиан 1.3%, бусад 0.3% Хүн амын өсөлт: 0.2 хувь (2022 он) Дундаж наслалт: 78
Шашин	75.6% христ, 3.8% бусад, 20.6% шашин шүтдэггүй
Төрийн албан ёсны хэл	Англи
Нийслэл	Брижтаун хот /110 мянган хүн амтай/
Засаг захиргааны нэгж	1 хот, 11 тойрогтой
Улсын бэлэг тэмдэг, онцлог	“Барбадосын улаан бахархал” гэгддэг цэцэг
Үндэсний баяр	1966 оны 11 дүгээр сарын 30-нд Их Британиас тусгаар тогтносон
Улс төрийн тогтолцоо	
Засаглалын хэлбэр	Парламентын Бүгд Найрамдах Улс
Ерөнхийлөгч	Сандра Мэсон /Sandra Mason/- 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс
Ерөнхий сайд	Миа Моттлей /Mia Mottley/- 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс
Гадаад хэргийн сайд	Керри Симмондс /The Hon. Kerrie Symmonds/- 2018 оны 05 дугаар сараас
Хууль тогтоох засаглал	Парламент нь 2 танхимтай бөгөөд Сенат 21, Ассамблей 30 суудалтай байна.
Сонгуулийн тогтолцоо	Сенат нь 21 суудалтай бөгөөд 12 гишүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор, 2 гишүүнийг Сөрөг хүчний тэргүүний санал болгосноор, 7 гишүүнийг өөрийн саналаар Амбан захирагч томилно. Ассамблей 30 суудалтай бөгөөд гишүүдийг 5 жилийн хугацаатай бүх нийтийн сонгуулиар сонгоно.
Сүүлийн сонгуулийн дүн	Хөдөлмөрчдийн нам 15 суудал Нэгдсэн прогрессив нам 1 суудал Иргэний хөдөлгөөн нам 1 суудал
Улс төрийн гол намууд	Хөдөлмөрийн нам
Эдийн засгийн үзүүлэлтүүд	
Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/	21,758 ам.доллар (2024 он)
Дундаж цалин	4,550 BBD (2,250 ам.доллар)

Эдийн засгийн гол салбарууд	Аялал жуулал жуулчлалын салбар нь ДНБ-ий 60 хувь, Гадаадын хөрөнгө оруулалтын 40 хувийг бүрдүүлдэг.
Санхүүгийн үйлчилгээ, давуу байдал	Барбадос Улс шинээр орж ирж буй хөрөнгө оруулагчдад сонирхол татахуйц татварын хөнгөлөлт үзүүлдэг. Тухайлбал, үндэстэн дамнасан корпорациудын сонирхлыг хамгийн их татдаг зүйл бол 15 сая ам.доллараас давсан орлогод 1 хувийн татвар ногдуулдаг явдал юм. Түүнчлэн Барбадосын татварын систем нь татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах, өв залгамжлал болон бэлэг хүлээн авах зэрэгт татвар ногдуулдаггүй байна.
Инфляцийн түвшин	2.4% (2024 он)
Хөдөлмөр эрхлэлт	Ажилгүйдлийн түвшин 7.7% (2024 он)
Гадаад худалдаа	Экспортын хэмжээ 61.3 сая ам.доллар: газрын тосны бүтээгдэхүүн, цагаан хэрэглэл, гар урлал, электрон эд анги, хүнсний бүтээгдэхүүн гаргадаг. Экспортын 62.2% - Польш, 9.5% - Камерун, 5.1% - АНУ, 4.5% - Их Британи улсууд эзэлдэг. Импортын хэмжээ 420.7 сая ам.доллар: хүнс, амьд амьтан, химийн бодис, машин механизм, тос зэргийг авдаг. Импортын 48% - АНУ, 4.2% - Испани, 47% - бусад орнууд эзэлдэг.
Байгалийн баялаг	Газрын тос, загас, байгалийн хий
Гадаад өр	ДНБ-ий 105 хувь (2024 оны байдлаар)
Мөнгөний нэгж, ханш	Албан ёсны ханшаар 2 Барбадос доллар нь 1 ам.доллартай тэнцэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан.

Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулснаар тус улстай дипломат харилцаа тогтоох манай улсын дотоодын процедур гүйцэлдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР